



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайвны өргөн чөлөө 16, Засгийн газрын IX байр,
Утас/Факс: (976-51) 26 23 50, E-mail: info@pcsp.gov.mn,
http://www.pcsp.gov.mn

2017.12.13 № А-1/3549

танай _____-ны № _____-т

**ТӨРИЙН (ОРОН НУТГИЙН) ӨМЧИТ
БОЛОН ТӨРИЙН (ОРОН НУТГИЙН)
ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН
ЭТГЭЭДЭД**

**Хөрөнгийн үнэлгээний талаар
авах зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолын дагуу төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийг үнэлэх, санхүүгийн тайланд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх ажлыг 2018 онд зохион байгуулна.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг баталгаажуулсан байдал, санхүүгийн тайланд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийн мэдээлэл нь үнэлгээ (дахин үнэлгээ) хийхэд хангалтгүй, зарим нь шаардлага хангахгүй байна.

Иймд Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2017 оны А/110 дугаар тушаалаар Сангийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Нийслэлийн өмчийн харилцааны газрын төлөөлөл бүхий байгуулагдсан Ажлын хэсгээс боловсруулсан зөвлөмжийг хавсралтаар хүргүүлэв.

Улсын хэмжээнд зохион байгуулагдах энэхүү үнэлгээний ажлыг байгууллагын удирдлагын шийдвэрээр Ажлын хэсэг байгуулан, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган, зөвлөмжийн дагуу бэлтгэл ажлыг 2018 оны 2 дугаар сард багтаан хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, хяналт тавьж ажиллах тул холбогдох мэдээллийг pcsp.gov.mn цахим хуудаснаас авч үнэлгээний ажилтай холбоотой санал болон бусад шаардлагатай мэдээллийг unelgee@pcsp.gov.mn хаягаар ирүүлж хамтран ажиллахыг хүсье.

Хувийг Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газар, Барилга, хот байгуулалтын яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт.

Хавсралт !!! хуудастай.

ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2017 оны 12 сарын 13-ний өдрийн
А-1/3549.. дугаар албан ёсны хэргийн хавсралт

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
ГАЗАР ЭЗЭМШИХ, АШИГЛАХ ЭРХИЙГ ҮНЭЛЭХ, ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН
ДАХИН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН БЭЛТГЭЛИЙГ ХАНГАХ ТУХАЙ ЗӨВЛӨМЖ**

Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын дүнгээр газар эзэмших, ашиглах эрх үнэлгээгүй, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ харилцан адилгүй буюу зах зээлийн үнээс доогуур байгаатай холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоол батлагдаж Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж, санхүүгийн тайланд тусгах, төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэхийг холбогдох яам, байгууллагуудад даалгасан юм.

Дээрх ажлыг зохион байгуулахын тулд ТӨБЗГ-ын даргын 2017 оны А/110 дугаар тушаалаар ГХЯ, СЯ, БХБЯ, ГХГЗЗГ, НӨХГ-аас холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан Ажлыг хэсгийг байгуулсан бөгөөд Ажлын хэсгийн ахлагчаар ТӨБЗГ-ын дэд дарга А.Дагвадорж ажиллаж байна.

Ажлын хэсэг мэргэжлийн үнэлгээчдийг сонгон төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшиж, ашиглаж буй газар, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний жишиг аргачлал боловсруулах, холбогдох байгууллагаар журам, зааврыг батлуулах, сургалт зохион байгуулах зэрэг хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн өнөөгийн байдал, өмнө хийсэн дахин үнэлгээний тухай болон үнэлгээ хийх хэрэгцээ, шаардлагын талаар

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа биет үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг Санхүү, эдийн засгийн сайд (хуучин нэрээр)-ын 2003 оны 342 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу 2004 онд, Сангийн сайдын 2009 оны 135 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу 2009 онд тус тус зохион байгуулсан бөгөөд түүнээс хойш дахин үнэлгээ хийгдээгүй юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд Монгол Улсад санхүүгийн тайлагналын (СТОУС) болон улсын секторын олон улсын стандартыг мөрдөхөөр заасан бөгөөд "СТОУС-16"-ийн 32 дугаар зүйлд "...хөрөнгийн бодит үнэд мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан бол жил бүр, үл мэдэгдэм өөрчлөлттэй бол 3-5 жил тутам үнэлгээ хийх нь тохиромжтой" гэж заасан.

Монгол Улсад газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж санхүүгийн тайланд бүртгээгүй бөгөөд 2009 оноос хойш үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ их хэмжээгээр нэмэгдэж, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа үл хөдлөх хөрөнгийн санхүүгийн тайланд туссан үнэ болон бодит үнэ цэнийн хооронд мэдэгдэхүйц зөрүү гарсан байна.

Монгол Улсын санхүүгийн зах зээлийн 90 орчим хувийг банкны зах зээл эзэлж байгаа нь өнөө үед төрийн өмчит үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ зах зээлийн үнэлгээнээс бага бөгөөд бодитоор илэрхийлэгдээгүй байгаатай тодорхой хэмжээгээр

холбоотой бөгөөд энэ нь эцсийн дүндээ төрийн өмчийг үнэгүйдүүлэх нэг нөхцөл болж байна.

Монгол Улсад газар эзэмших, ашиглах эрхийг гар дамжуулан худалддаг, төрийн болон орон нутгийн өмчийн газрыг бусдад үнэ төлбөргүй шилжүүлдэг боловч тухайн газар дээрх үл хөдлөх хөрөнгө, тухайн газрыг төрийн байгууллагад эзэмшүүлэх хэрэгцээ шаардлагыг харгалзан үздэггүй, дуудлагын худалдаагаар худалдахад их хэмжээний үнэ цэнэд хүрдэг зэрэг бодит байдлыг дурдаж болно.

Төрийн өмчийг хадгалах, хамгаалах, тухайн байгууллагын төрийн ажил үйлчилгээг эрхлэхэд шаардагдах газрын баталгааг хангах газар эзэмших, ашиглах эрхийг дураараа шилжүүлэх, худалдах асуудлыг таслан зогсоох зорилгоор үнэлгээ хийж, санхүүгийн тайланд тусгах шаардлага гарч байна.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд байгууллагынхаа эзэмшил(санхүүгийн тайланд бүртгэлтэй) -д байгаа үл хөдлөх хөрөнгө бүрийн доорх газрыг эзэмших, ашиглах эрхийг баталгаажуулсан байх ёстой. Гэтэл баталгаажуулаагүй (гэрчилгээгүй, гэрээгүй, кадастрын зураггүй), эсвэл баримт бичгийн бүрдэл дутуу (гэрчилгээ, гэрээ, кадастрын зургийн аль нэг нь байхгүй), тэдгээр баримт бичигт заасан газрын хэмжээ хоорондоо харилцан адилгүй буюу зөрүүтэй (орсон өөрчлөлийг албан ёсоор баталгаажуулаагүй), газар эзэмших эрхийг улсын бүртгэлд бүртгүүлээгүй, газрын зориулалт болон хэмжээг зөвшөөрөлгүй өөрчилсөн, байгууллагын мэдлийн газар дээр өөр байгууллагын эзэмшил, өмчлөлийн барилга байгууламж бариулсан зэрэг нийтлэг зөрчил дутагдал байна.

Үл хөдлөх хөрөнгийн хувьд барилгын паспортыг бүрэн гүйцэд хөтлөөгүй тул хийц, хэмжээ тодорхойгүй, барилгын доторх давхар бүрийн схем зураглал байхгүй тул хэмжээг баталгаажуулсан баримт байхгүй, барилгад хамаарах инженерийн байгууламж (ус, дулаан, цэвэр бохир усны хангамж, ариутгах татуурга, галын дохиолол, зоорийн давхар г.м.)-ийн талаарх мэдээлэл дутуу, барилгыг 2 болон түүнээс дээш этгээд хувааж эзэмшиж байгаа тохиолдолд заагийг тодорхойлсон схем зураг үйлдээгүй, хэмжээг баталгаажуулаагүй, барилгын чанар байдлын талаар холбогдох мэргэжлийн байгууллагаас гаргасан дүгнэлт (хэсэгчилсэн), гал, үер, ус, газар хөдлөл, нуралтын талаарх тэмдэглэл баримт хадгалагдаагүй, барилга байгууламжийн фото зураг (4 талаас нь авсан)-ийг паспортод оруулаагүй зэрэг нийтлэг зөрчил, дутагдал байна.

Өмнөх жилүүдэд хийсэн дахин үнэлгээний туршлага, дээр дурдсан хэрэгцээ шаардлагын үүднээс үнэлгээний ажил эхлэхээс өмнө буюу 2018 оны 2 дугаар сард багтаан бэлтгэл ажлын хүрээнд хийж гүйцэтгэх ажлын дараах зөвлөмжийг байгууллага бүрт хүргүүлэх шаардлагатай гэж үзлээ.

1. ХАМРАХ ХҮРЭЭ

Монгол Улсын Иргэний хуулийн 84 дүгээр зүйлийн 84.3-т заасны дагуу "газар, түүнээс салгамагц зориулалтын дагуу ашиглаж үл болох эд юмс" үл хөдлөх хөрөнгөд хамаарна. Үүнд:

- 1.1. Газар эзэмших, ашиглах эрх
- 1.2. Газар дээрх барилга байгууламж

- 1.2.1 Барилга (маягт-3, маягт 3.1.)
- 1.2.2 Инженерийн ил болон далд байгууламж (холбоо, цахилгаан, дулаан, цэвэр, бохир усны г.м.) (маягт-3, маягт 3.1.)
- 1.2.3 Нийтийн эзэмшлийн байгууламж (маягт-4) (нийтийн эзэмшлийн хучилттай болон зүлэгжүүлсэн талбай, мод, бут сөөг, биеийн тамирын талбай, түүний тохижилтын хөрөнгө, автомашины зогсоол, сандал, сүүдрэвч, үерийн далан суваг, явган зам, гэрэлтүүлгийн байгууламж, ургамлын хайс хашлага г.м.)
- 1.2.4 Худаг (маягт-9)
- 1.2.5 Дуусаагүй барилга (маягт ТӨ-1)
- 1.2.6 Улсын болон орон нутгийн чанартай зам (маягт ТӨ-13.1)
- 1.2.7 Улсын болон орон нутгийн чанартай гүүр(маягт-ТӨ-13.2)
- 1.2.8 Төмөр зам (маягт 3)

Эдгээр хөрөнгийг холбогдох маягтын асуулга тус бүрээр гаргаж, тоо хэмжээ, зааг, байршлыг тогтоож (мониторинг хийх) үнэлвэл зохих хөрөнгийн жагсаалтыг бэлтгэнэ.

2. ХОЛБОГДОХ БАРИМТ МАТЕРИАЛЫГ БҮРДҮҮЛЭХ ТАЛААР

Тухайн байгууллагын хөрөнгийн дансанд тодорхой үнэ цэнээр бүртгэсэн болон бүртгээгүй (салгаж) төрийн өмчийн эд хөрөнгийн "төрийн өмч", "тухайн байгууллагын өмч" гэдгийг батлах эрх зүйн баримт бичиг нь чухал ач холбогдолтой болно.

Үнэлгээ хийхэд дараах баримт материалыг бүрдүүлсэн байх шаардлагатай:

- Газар, үл хөдлөх хөрөнгө эзэмших, ашиглах эрх зүйн баримтыг (Дуусаагүй барилга байгууламжийн доорх газрыг баталгаажуулах асуудлыг орхигдуулсан зөрчил нийтлэг байдаг) бэлтгэх;
- Үл хөдлөх хөрөнгийг олж авсан, шилжүүлсэн (худалдан авсан, шилжүүлэн авсан, шинээр ашиглалтад авсан, эзэмшигч өөрчлөгдсөн, хэсэгчлэн шилжсэн, хувьчлагдсан хөрөнгийг дагаж хасагдсан гэх мэт) шийдвэр;
- Барилга, үл хөдлөх хөрөнгийн хувийн хэрэг (уг хувийн хэрэгт зураг, схем, их засвар, дахин үнэлгээний гэх мэт түүхчилсэн мэдээллийг бүрэн багтаах);
- Сангийн сайдын шийдвэрээр 2004, 2009 онд явагдсан дахин үнэлгээний баримтын байгууллага дээр хадгалагдаж буй хувийг архиваас авч бэлтгэх;
- Барилгын анхны зургаас барилга, үл хөдлөх хөрөнгийн хэмжээ, инженерийн шугам сүлжээний зураглалыг харуулсан хэсгийг хуулбарлан бэлтгэх;
- Барилгын давхар тус бүрийн ерөө тасалгаа, тэдгээрийн хэмжээг харуулсан схем зураглал;
- Барилгын хамтран (хувааж) эзэмшигчдийн хооронд барилгын заагийг тогтоосон акт;
- Барилгын чанар байдлын талаар холбогдох мэргэжлийн байгууллагаас гаргасан дүгнэлт (хэсэгчилсэн), гал, үер ус, газар хөдлөл, нуралтын талаарх тэмдэглэл, баримт, дүгнэлт;

- Барилга байгууламжийн фото зураг (хийцийг харуулж тал, талаас нь авсан);
- Төмөр зам (дагнасан болон салбар зам)-ын гэрчилгээ;
- Сүүлийн жилүүдэд байгууллагынхаа хөрөнгийг хөрөнгийн үнэлгээний (хөндлөнгийн) байгууллагаар үнэлүүлсэн бол үнэлгээний тайлан (хуулбар), түүний үр дүнг санхүүгийн тайланд тусгасан байдлын талаарх тайлбар.

Дээр дурдсан баримтаас өөрийн байгууллагын хөрөнгөд хамаарах болон шаардлагатай мэдээллийг бүрдүүлэн, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгө тус бүрээр хувийн хэрэг бүрдүүлэх шаардлагатай.

3. ХӨРӨНГИЙН БОДИТ БАЙДЛЫГ ТОГТООХ АРГА ХЭМЖЭЭ АВАХ

Газар болон түүн дээрх барилга байгууламж, нийтийн эзэмшлийн хөрөнгийн бүртгэлийг газрын кадастрын зургаар тодорхойлсон хил, хязгаарын дотор "байршил зүйн зураг" хийгээгүй тул байгууллагынхаа мэдлийн газрын зааг, түүн дээрх үл хөдлөх хөрөнгийн байршил, нэршил, хэмжих нэгжийг мэддэггүй, хэд хэдэн барилга байгууламжийг нэгтгэн нэг нэрээр бүртгэснээс хөрөнгө нэг бүрийн бодит байдал буруу илэрхийлэгддэг зэрэг нийтлэг зөрчил дутагдал байна.

Иймд газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд мониторинг хийж, бодит байдлыг тогтоолохд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай:

- 3.1. Газар эзэмших, ашиглах эрхийг баталгаажуулах, зөрчлийг арилгах; (Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд өөрийн регистрийн дугаар болон газрын нэгж талбарын дугаар зэрэг мэдээллийг ашиглан байгууллагын эзэмшлийн газрыг www.egazar.gov.mn хаягаар газар зүйн мэдээллийн системд бүртгэсэн байдлыг шалган, оруулаагүй бол зөрчлийг арилгах, шаардлагатай тохиолдолд аймаг, нийслэлийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Нийслэлийн газрын албанд хандан шийдвэрлүүлэх);
- 3.2. Барилга байгууламжийн хийц, хэмжээс, инженерийн ил, далд байгууламжийн эхлэл, төгсгөлийн цэг, хэмжээ, хүчин чадлыг нэг бүрчлэн шалгаж зөв тодорхойлох;
- 3.3. Байгууллагынхаа эзэмшлийн газар дээрх нийтийн эзэмшлийн байгууламжийг үнэлж бүртгэлд тусгаагүй зөрчил гарч байгаа тул тооллого явуулж тоо хэмжээг шинэчлэн тогтоох;
- 3.4. Барилгын нийт болон ашигтай талбайн хэмжилт хийж давхар бүрийн схем зураглалыг бэлтгэх (мэргэжлийн зураг байхгүй бол өөрсдөө зурж, өрөө, тасалгаа бүрийн талбайг тодорхойлох);
- 3.5. Байгууллагын эзэмшлийн газар дээр энэхүү зөвлөмжийн "1. Хамрах хүрээ"-нд заасан тухайн байгууллагад хамаарах хөрөнгийг байршуулан "Байршил зүйн зураглал" үйлдэж, тулган баталгаажуулалт хийх. Байгууллагын эзэмшлийн бүх үл хөдлөх хөрөнгө энэхүү байршил зүйн зураг дээр (олон байршилд хөрөнгө байгаа бол тухайн газар бүрт) байршсан байх ёстой;

3.6. Байгууллагын эзэмшилд (бодит) байгаа үл хөдлөх хөрөнгийг санхүүгийн тайлангийн бүртгэлтэй тулган баталгаажуулах.

Тухайн байгууллагын хөрөнгийн бодит байдал санхүүгийн тайланд туссанаас зөрүүтэй, эсвэл дээр дурдсан мэдээ мэдээлэл байхгүй бол тухайн хөрөнгийг үнэлэх боломжгүй юм.

Газар, үл хөдлөх хөрөнгийн бодит байдлыг байгууллагынхаа нөөц бололцоогоор тодорхойлох боломжгүй тохиолдолд мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авах, улмаар хэмжилт, зураглал хийлгэх нь зүйтэй.

4. НЭГДСЭН ДҮГНЭЛТ, АКТ, ТАЙЛБАР БЭЛТГЭН БАТАЛГААЖУУЛАХ

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд бүр удирдлага (дарга, захирал)-ын тушаалаар үнэлгээний ажлын бэлтгэлийг хангах, зохион байгуулах ажлыг хийж гүйцэтгэх Ажлын хэсэг (Өмч хамгаалах байнгын зөвлөлийг оролцуулан) байгуулан хариуцуулж, үр дүнг ТӨБЗГ болон Нийслэлийн өмчийн харилцааны газар, Орон нутгийн өмчийн газарт хянуулж (шалгуулж), хүлээлгэн өгнө.

Өмч хамгаалах байнгын зөвлөл (Ажлын хэсэг) үнэлвэл зохих хөрөнгийн жагсаалтыг бэлтгэн гаргаж, үнэлгээ хийхэд илэрч буй зөрчил дутагдал, тулгарч болох саад бэрхшээл (алслагдмал байрладаг, хөрөнгийн үнэлгээг салгах боломжгүй, хэмжээг тодорхойлох боломжгүй, маргаантай, санхүүгийн тайланд туссан хөрөнгө бодит байдалтай зөрүүтэй г.м) зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч, асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар "Нэгдсэн акт дүгнэлт"-д тусгана.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Нийслэлийн өмчийн харилцааны газар, Орон нутгийн өмчийн газрууд үнэлгээний ажилд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, хяналт тавьж ажиллах тул холбогдох мэдээллийг www.pcsp.gov.mn цахим хуудаснаас авч санал болон бусад шаардлагатай мэдээллийг тухай бүр unelgee@pcsp.gov.mn хаягаар ирүүлж ажиллана уу.

Үнэлгээний комиссын гишүүд хөрөнгө нэг бүрийг хэмжиж үзэх боломжгүй бөгөөд Байгууллагын Ажлын хэсэг (Өмч хамгаалах байнгын зөвлөл)-ийн тодорхойлсон хэмжээ, зааг, чанар байдлын дүгнэлтийг үндэслэн үнэлгээ хийх юм.

Ажлын хэсэг (Өмч хамгаалах байнгын зөвлөл) өөрийн байгууллагын үнэлвэл зохих хөрөнгийн тоо хэмжээ, чанар байдлыг тодорхойлж холбогдох маягт тус бүрээр бэлтгэх бөгөөд асуулгыг бүрэн, үнэн зөв бөглөх шаардлагатай.

Засгийн газрын 2013 оны 38 дугаар тогтоолын дагуу эзэмшил газрын хэмжээ, зориулалт өөрчлөгдөхөд БХБЯ, ТӨБЗГ, аймаг, нийслэлийн ИТХ-аас зөвшөөрөл авсан байх шаардлагатай тул зөвшөөрөлгүйгээр газар шилжүүлэх, зориулалт өөрчлөх асуудлыг таслан зогсоох шаардлагатай.

Үнэлгээний ажилд шаардагдах баримт мэдээлийг дараах байдлаар нэгтгэн гаргана:

- Үнэлвэл зохих нийт хөрөнгийн жагсаалт;
- Газрын багц баримт;
- Эзэмшиж, ашиглаж буй газар дээрх "Байршил зүйн схем зураг" ;
- Байгууллага бүрийн Өмч хамгаалах байнгын зөвлөл (Ажлын хэсэг)-ийн гаргасан Нэгдсэн акт дүгнэлт;
- ТӨБЗГ-ын "Төрийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-ийн програм хангамжид үнэлвэл зохих хөрөнгийн мэдээллийг оруулах (оруулсан мэдээлэлд нэмэлт хийх, зураг файл хавсаргах).

Засгийн газрын шийдвэрээр зөвхөн газар, үл хөдлөх хөрөнгийг үнэлгээнд хамруулахаар заасан боловч байгууллагын зүгээс үнэлвэл зохих хөрөнгийн жагсаалтад хөдлөх хөрөнгийг зайлшгүй оруулах хэрэгцээ шаардлага байгаа бол энэ тухай ТӨБЗГ, Ажлын хэсэгт 2018 оны 1 дүгээр сард багтаан мэдэгдэнэ үү.

"БАЙРШИЛ ЗҮЙН ҮЛГЭРЧИЛСЭН СХЕМ ЗУРАГ"-ИЙГ ЭНЭХҮҮ ЗӨВЛӨМЖИД ХАВСАРГАВ.


Энэхүү үнэлгээний ажил нь Засгийн газрын үндсэн хөрөнгийн активын бодит үнэ цэнийг тодорхойлох зорилгоор хийгдэж байгаа тул тухайн байгууллагын нягтлан бодогч, санхүүгийн ажилтнаас гадна байгууллагын удирдлага (дарга, захирал) бусад холбогдох эрх бүхий албан тушаалтан нар хариуцлагатай, идэвхи санаачлагатай оролцох нь зүйтэй.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

АЖЛЫН ХЭСЭГ

-----oO-----

Байгууллагын эзэмшлийн газар дээрх барилга байгууламжийн БАЙРШИЛ ЗҮЙН СХЕМ (загвар)



ТАНИХ ТЭМДЭГ

	Барилга		Барилга
	Эзэмшил газрын зол		спортын заалтын барилга
	Барилга		соёлын төвийн барилга
	Барилга		Барилгууд
	Авто зам		Явган хүний зам
	Хашаа		Авто зогсоол
	Нэгдсэн жогийн сав		Ногоон байгууламж
	Барилга		спортын заалтын барилга
	Барилга		соёлын төвийн барилга
	Барилга		Барилгууд
	Барилга		Явган хүний зам
	Барилга		Авто зогсоол
	Барилга		Ногоон байгууламж

Талбай


Д/д	Талбайн төрөл	Хэмжээ /м2/	
		Барилга	Талбай
1	Барилга	1453.72	1453.72
2	Явган зам	562.95	1834.80
3	Машин зогсоол	1271.85	700.79
4	Ногоон байгууламж	700.79	3089.31
	Нийт	3089.31	3089.31

..... БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР, УЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН
 БАЙРШИЛ ЗҮЙН СХЕМ ЗУРАГ /загвар/



*загвар

1-Р ДАВХРЫН БАЙГУУЛАЛТ М1:200



Өрөөний тодорхойлолт

Д/д	Өрөөний нэр	Талбай /м ²
1	Спортын талбай	784.0
2	Гонх	13.3
3	Гонх	13.3
4	Хулээн авах танхим	30.6
5	Үйлчлэгчийн өрөө	2.8
6	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан ариун цэврийн өрөө	4.2
7	Ариун цэврийн өрөө	25.8
8	Олон гаралт сургалтын өрөө	50.9
9	Тенисний өрөө	39.4
10	Тонот гэхөөрөмж хадгалах өрөө	7.7
11	Хушас солих өрөө /эр/	13.6
12	Душ, ариун цэврийн өрөө /эр/	9.8
13	Хушас солих өрөө /эм/	13.6
14	Душ, ариун цэврийн өрөө /эм/	9.8
15	Фитнесийн өрөө	39.4
16	Агуулах	7.8
17	Багш дасгалжуулагчийн өрөө	17.4
18	Анхн туслахийн өрөө	17.3
19	Гонх	8.0
20	Хонгил	69.2
	Нийт	1177.9